



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 367

Улаанбаатар хот

Дуудлагын худалдаа зохион байгуулах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ, тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 5 нэрийн, нийт 91,470,727.27 (ерэн нэгэн сая дөрвөн зуун далан мянга долоон зуун хорин долоон төгрөг хорин долоон мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Насантогтох, "Алтай-Улиастайн эрчим хүчний систем" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал А.Пүрэвсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Нээлттэй дуудлагын худалдаанаас олох орлогыг зохих журмын дагуу компанийн дансанд төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Худалдсан автомашины улсын дугаарыг шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2020 оны 3 дугаар улиралд багтаан холбогдох мэдээ, тайлангийн маягтын хамт Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

000708

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 07 дугаар сарын 06 ны өдрийн
 367 дугаар тогтоолын хавсралт

**"АЛТАЙ-УЛИАСТАЙН ЭРЧИМ ХҮЧНИЙ СИСТЕМ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
 ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ**

Д/д	Суудлын автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Байршил, салбар
1	Хьюндай Портер, 68-71 ГАА, КМФХК07ВРХМ33934	2009/2009	6,000,000.00	6,000,000.00	-	1,000,000.00	Толгой компани
2	УАЗ 22069-033 Пургон, 21-74 ЗАН, 374100В0466440	2011/2012	17,272,727.27	17,272,727.27	-	800,000.00	Завхан салбар
3	УАЗ 22069 Пургон, 21-84 ЗАА, 0436619	2010/2011	21,560,000.00	21,560,000.00	-	800,000.00	Завхан салбар
4	Субару Форестер, 27-16 ЗАН, SF5117563	2000/2008	10,000,000.00	10,000,000.00	-	1,000,000.00	Завхан салбар
5	Тусгай зориулалтын Аугер кран 5тн, 70-57 ЗАА, SAC424-0086	1997/2007	36,638,000.00	36,638,000.00	-	2,800,000.00	Завхан салбар
			91,470,727.27	91,470,727.27	-	6,400,000.00	
Нийт дүн					-	(зургаан сая дөрвөн зуун мянган)	-
						(ерэн нэгэн сая дөрвөн зуун далан мянга долоон зуун хорин долоон төгрөг хорин долон мөнгө)	